



**“ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ  
БАЙГУУЛАМЖ” ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН  
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/32

Замын-Үүд сум

Комисс томилох тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.2.1, 29.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 269 дугаар тогтоолын 3.1 дэх заалт, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журмын 2.4.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын байранд гарсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс”-ын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, комиссын ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын хэмжээнд гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдлыг Засгийн газрын “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг үндэслэн шуурхай үнэн зөв бүртгэж тогтоохыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдол бүрд шуурхай, үнэн зөв мэдээлэл өгч, тухайн хэсгийг комисс шалгах хүртэл хэвээр хадгалж байхыг нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер /Т.Мөнхзаяа/-д даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын 2020 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/31 тоот тушаал хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ  Г.ГАНСҮХ



0441220032


“ШТШАБ” ТӨҮГ-ын захирлын 2022 оны 05 сарын  
02 ны өдрийн 1/32 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**НЭГ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ОРОН  
ТООНЫ БУС БАЙНГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

- |                   |   |
|-------------------|---|
| 1. Комиссын дарга | Ерөнхий инженер Төгсжаргалын Мөнхзаяа   |
| 2. Нарийн бичиг   | ХАБЭА-н ажилтан Дагвагийн Мөнхнаран   |
| 3. Гишүүд         | Ерөнхий нягтлан бодогч Булганы Дэлгэрдалай<br>Дотоод аудит, хуулийн зөвлөх Долгоржавын Батчимэг<br>Лабораторийн эрхлэгч Баярсайханы Мөнх-Ундрал |

“ШТШАБ” ТӨҮГ-ын захирлын 2022 оны 05 сарын  
02-ны өдрийн 132 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## ХОЁР. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ОРОН ТООНЫ БУС БАЙНГЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

**Зорилго:** “ШТШАБ” ТӨҮГ-т гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан хүчин зүйлийг судлан бүртгэх, тайлагнах.

### КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

1. Орон тооны бус байнгын комисс нь үйлдвэрлэлийн осол хурц хордлогын шалтгааныг тогтоох, дүгнэлт гаргахдаа Засгийн газрын “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг мөрдлөг болгоно.
2. Орон тооны бус байнгын комисс нь үйлдвэрлэлийн осол хурц хордлого гарснаас хойш 48 цагийн дотор судлан бүртгэх бөгөөд акт үйлдэн комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, байгууллагын тамга тэмдэг дарсан байна.
3. Орон тооны бус байнгын комисс нь үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэсэн акт, дүгнэлтийг байгууллагын захиралд тухай бүр нь танилцуулна.
4. Орон тооны бус байнгын комисс нь үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан холбогдох актыг сумын хөдөлмөрийн хяналтын болон эрүүл ахуйн улсын байцаагчид хүргүүлнэ.
5. Орон тооны бус байнгын комисс нь үйлдвэрлэлийн осол хурц хордлого, осол дөхсөн тохиолдол бүрийг бүтгэж бүртгэлийг үндэслэн судалгаа гарган дүн шинжилгээ хийж осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж ажиллана.
6. Орон тооны бус байнгын комисс нь шаардлагатай тохиолдолд үйлдвэрлэлийн осол хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийн талаар тухайн чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн байцаагч болон ажил олгогчоос хараат бус мэргэжилтэн шинжээч, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж болно.
7. Орон тооны бус байнгын комисс нь үйлдвэрлэлийн осол хурц хордлогын акт, дүгнэлтийг 4 хувь үйлдэж, харьяа нийгмийн даатгалын хэлтэс, хөдөлмөрийн хяналтын болон эрүүл ахуйн улсын байцаагчид хүргүүлэх бөгөөд осолдогч буюу түүний гэр бүлд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судалж бүртгэсэн актыг өгнө.

8. Орон тооны бус байнгын комисс нь үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлаж бүртэгсэн акт, дүгнэлтийг архивын нэгж болгон хадгална.

9. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас ажилтны эрүүл мэндэд хүнд гэмтэл, бэртэл учирсан, нас барсны улмаас мэргэжлийн байгууллагын шинжилгээ, магадалгаа шаардлагатай бол 21 хоногийн дотор судлан бүртгэнэ.

10. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарснаас хойш 6 сарын хугацаа өнгөрсөн тохиолдолд акт, дүгнэлт нөхөн гаргахгүй.

11. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүдэд жил бүр 50,000.0 /тавин мянган/ төгрөгийн урамшуулал олгоно.

### **КОМИССЫН ЭРХ, ҮҮРЭГ**

➤ **Комисс нь дараах эрхтэй байна.**

1. Үйлдвэрлэл, үйлчилгээний талбай болон ажлын байранд нэвтрэн орж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нөхцөл байдалтай биечлэн танилцах.

2. Мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө, тусламж авах зорилгоор шаардлагатай тохиолдолд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх ажиллагаанд мэргэжилтэн, шинжээч оролцуулах, ослын талаар техникийн тооцоо, лабораторийн шинжилгээ, туршилт хийлгүүлэх, осол гарсан ажлын байрны эрсдэлийн үнэлгээг дахин хийлгэж, дүгнэлт гаргуулах.

3. Осолдогч болон осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад шаардлагатай ажлын байр, техник хэрэгсэл, унаагаар хангуулах.

➤ **Комисс нь дараах үүрэг гүйцэтгэнэ.**

1. Нөхцөл байдалтай газар дээр нь танилцан, судалж бүртгэх үйл ажиллагааг эхлүүлэх.

2. Үйлдвэрлэлийн осол хурц хордлого гарахад хүргэж болзошгүй бөгөөд бусдын амь нас, эрүүл мэндэд аюултай, ажлын байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, орчны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулах талаар ангийн удирдлагад шаардлага тавих, зөвлөмж өгөх.

3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад гарсан иргэдийн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, ажлын 3 хоногийн дотор магадлан шалгаж шийдвэрлэх.

4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг шалтгаан, хүчин зүйлийг судлан бүтгэсэн акт, дүгнэлтийг үндэслэн нийт ажилтнуудад осол, хурц хордлого гарсан шалтгаан, нөхцөл болон цаашид үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгч, сэрэмжлүүлэх арга хэмжээг нэн даруй авах, ангийн удирдлагад шаардлага, зөвлөмж хүргүүлэх.

5. Орон тооны бус байнгын комисс нь үйлдвэрлэлийн осол хурц хордлогын талаарх орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад “Үйлдвэрлэлийн осол хурц хордлогын тухай яаралтай мэдэгдэх хуудас”-ын дагуу бичгээр болон утсаар мэдэгдэнэ.

6. Үйлдвэрлэлийн осол хурц хордлогын талаарх мэдээллийг хүлээн авмагц осолдогчид анхан шатны тусламж үзүүлж, эмнэлэгт хүргүүлнэ.

7. Цагдаа, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн байцаагч, комисс судалгаа, шинжилгээ хийх хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн осол хурц хордлого гарсан ажлын байрыг хамгаалалтад авна.

8. Үйлдвэрлэлийн осол хурц хордлого гарсан ажлын байрыг хамгаалалтад авах нь ажлын байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, эсхүл бусад ажилтны эрүүл мэнд, орчны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөө бол нөхцөл байдлыг дүрс бичлэг, гэрэл зураг болон бүдүүвч зургаар баримтжуулсан байна.